



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгж ОНӨТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: НТАГ-2024/50/НА-СТА-ОНА

Цахим хуудас:
www.audit.mn

Улаанбаатар хот
2024 он

Санхүү-нийцлийн аудитын хэлтсийн дарга: Х.Түвшинбаяр
Утас: 327734 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Отгонбаяр
Утас: 315558 Цахим хаяг: otgonbayarda@audit.gov.mn

Ахлах аудитор: Г.Долгорсүрэн
Утас: 325093 Цахим хаяг: dolgorsureng@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	10
3.1 Компани/ТӨҮГ, түүний үйл ажиллагаа	10
3.2 Компани/ТӨҮГ-ын гадаад, дотоод орчин	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	11
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	13
4.1 Ерөнхий зүйл	13
4.2 Материаллаг байдал.....	13
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	13
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	13
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	14
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	15
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	15
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	18

Товчилсон үгийн жагсаалт

НТАГ	Нийслэл дэх Төрийн аудитын газар
НББОУС	Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ОНӨТҮГ	Орон нутгийн өмчит, төсөвт үйлдвэрийн газар
УТҮГ	Улсын төсөвт үйлдвэрийн газар
ТББ	Төрийн бус байгууллага
ХК	Хувьцаат компани
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2024.03.15 № 517

танай _____-ны № _____-т

НИЙСЛЭЛ УЛААНБААТАР ХОТЫН
АВТО ЗАМЫН ТҮГЖРЭЛИЙГ
БУУРУУЛАХ НЭГДСЭН ТӨСӨЛ
ХЭРЭГЖҮҮЛЭХ НЭГЖ ОНӨТҮГ-ЫН
ЗАХИРАЛ Б.ЭРДЭНЭСАЙХАН
ТАНАА

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгж ОНӨТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгж ОНӨТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн 134,862.3 мянган төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан нь дангаараа буюу эсвэл нийтээрээ санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй, санхүүгийн тайлангийн "тохиолдсон байх", "үнэн зөв байх", "нийцсэн бөгөөд зохистой байх", эрх ба үүрэг" батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

D:\Desktop\2024\Word\Резан Биен\2024.03.15\002022057

002022057

Аудитын гол асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд 4 зорилтын хүрээнд 60 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 87.9 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



М.ЭРДЭНЭЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>8,085,772,168.88</u>	<u>9,054,403,798.75</u>
33	АВЛАГА	1,880,253.84	3,655,548.71
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	1,380,253.84	3,155,548.71
335	Бусад авлага	500,000.00	500,000.00
3351	Байгууллагаас авах авлага	500,000.00	500,000.00
34	УРЬДЧИЛГАА	15,000,000.00	-
34600	Урьдчилж гарсан зардал	15,000,000.00	-
35	БАРАА МАТЕРИАЛ	24,449,695.05	36,306,030.05
354	Хангамжийн материал	24,449,695.05	36,306,030.05
35410	Бичиг хэргийн материал	2,597,280.00	2,949,280.00
35440	Түлш, шатах тослох материал	240,665.00	-
35470	Бусад хангамжийн материал	21,611,750.05	33,356,750.05
36	НӨӨЦИЙН БАРАА	8,044,442,219.99	9,014,442,219.99
36800	Бусад эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ/	8,044,442,219.99	9,014,442,219.99
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>132,304,848.44</u>	<u>115,588,909.11</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	132,304,848.44	115,588,909.11
392	Биет хөрөнгө	131,239,315.14	115,588,909.11
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	112,153,780.00	152,424,985.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(23,662,825.87)	(72,396,972.66)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	46,098,120.00	46,098,120.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(3,349,758.99)	(10,537,223.23)
393	Биет бус хөрөнгө	1,065,533.30	-
39303	Бусад биет бус хөрөнгө	11,751,260.00	27,802,800.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	(10,685,726.70)	(27,802,800.00)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>8,218,077,017.32</u>	<u>9,169,992,707.86</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>9,138,740.56</u>	<u>8,856,240.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	9,138,740.56	8,856,240.00
413	Өглөг	9,138,740.56	8,856,240.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	480,555.56	-
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	8,658,185.00	3,856,240.00
4136	Бусад өглөг	-	5,000,000.00
41361	Байгууллагад төлөх өглөг	-	5,000,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>8,208,938,276.76</u>	<u>9,161,136,467.86</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	8,208,938,276.76	9,161,136,467.86
512	Хуримтлагдсан үр дүн	8,208,938,276.76	9,161,136,467.86
51210	Өмнөх үеийн үр дүн	8,208,938,276.76	8,208,938,276.76
51220	Тайлант үеийн үр дүн	-	952,198,191.10
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>8,218,077,017.32</u>	<u>9,169,992,707.86</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	8,044,804,623.99	2,477,744,133.90
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	8,044,804,623.99	-
120	Нийтлэг татварын бус орлого	8,044,804,623.99	-
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	8,044,804,623.99	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	175,000.00	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	8,044,629,623.99	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	-	2,477,744,133.90
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	1,507,744,133.90
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	-	1,507,744,133.90
1330	Төсвийн захирагчдаас	-	970,000,000.00
133003	Хөрөнгийн	-	970,000,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,635,866,347.23	1,525,545,942.80
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,635,866,347.23	1,525,545,942.80
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,190,024,274.55	1,525,545,942.80
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	713,169,852.42	955,331,244.39
210101	Үндсэн цалин	646,920,443.33	901,472,214.39
210102	Нэмэгдэл	-	2,310,000.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	19,678,500.00	41,552,120.00
210104	Урамшуулал	46,570,909.09	9,996,910.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	88,971,915.42	121,460,297.56
210201	Тэтгэврийн даатгал	60,616,359.87	83,472,348.64
210202	Тэтгэмжийн даатгал	7,131,698.54	8,903,869.58
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,741,196.53	7,779,049.97
210204	Ажилгүйдлийн даатгал	1,219,263.42	1,857,404.48
210205	Эрүүл мэндийн даатгал	14,263,397.06	19,447,624.89
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	34,653,314.00	31,057,681.00
210304	Байрны түрээс	34,653,314.00	31,057,681.00
2104	Хангамж, бараа материалын зардал	109,343,454.11	81,216,106.00
210401	Бичиг хэрэг	14,836,400.00	5,508,920.00
210402	Тээвэр, шатахуун	63,616,919.00	54,561,396.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7,594,535.11	11,689,490.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	23,295,600.00	9,456,300.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	38,793,500.00	1,959,100.00
210604	Урсгал засвар	38,793,500.00	1,959,100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	162,222,927.04	243,955,948.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	161,322,927.04	232,659,948.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	10,000,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	900,000.00	1,296,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	42,869,311.56	90,565,565.85
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,171,000.00	17,526,881.52
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	37,698,311.56	73,038,684.33
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	445,842,072.68	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	445,842,072.68	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	445,842,072.68	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	6,408,938,276.76	952,198,191.10
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	6,408,938,276.76	952,198,191.10

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>1,800,175,000.00</u>	<u>2,477,744,133.90</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	175,000.00	-
120	Нийтлэг татварын бус орлого	175,000.00	-
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	175,000.00	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	175,000.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,800,000,000.00	2,477,744,133.90
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,800,000,000.00	1,507,744,133.90
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,800,000,000.00	1,507,744,133.90
1330	Төсвийн захирагчдаас	-	970,000,000.00
133003	Хөрөнгийн	-	970,000,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>1,630,171,840.00</u>	<u>1,451,421,388.90</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,630,171,840.00	1,451,421,388.90
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,184,329,767.32	1,451,421,388.90
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	714,869,550.74	957,587,094.83
210101	Үндсэн цалин	658,115,881.29	903,728,064.83
210102	Нэмэгдэл	-	2,310,000.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	19,800,000.00	41,552,120.00
210104	Урамшуулал	36,953,669.45	9,996,910.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	88,971,915.38	121,460,297.55
210201	Тэтгэврийн даатгал	60,616,359.87	82,652,405.77
210202	Тэтгэмжийн даатгал	7,131,698.52	9,723,812.44
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,705,358.82	7,779,049.96
210204	Ажилгүйдлийн даатгал	1,255,101.12	1,857,404.49
210205	Эрүүл мэндийн даатгал	14,263,397.05	19,447,624.89
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	34,653,314.00	31,057,681.00
210304	Байрны түрээс	34,653,314.00	31,057,681.00
2104	Хангамж, бараа материалын зардал	107,322,010.11	86,089,286.00
210401	Бичиг хэрэг	16,966,180.00	5,508,920.00
210402	Тээвэр, шатахуун	55,011,995.00	59,122,676.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8,094,535.11	11,689,490.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	27,249,300.00	9,768,200.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	49,737,500.00	10,357,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,544,000.00	-
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	6,400,000.00	6,339,000.00
210604	Урсгал засвар	38,793,500.00	4,018,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	176,422,927.09	225,995,048.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	175,522,927.09	212,659,948.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	10,000,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	900,000.00	3,335,100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	12,352,550.00	18,874,981.52
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	12,352,550.00	18,874,981.52
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	445,842,072.68	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	445,842,072.68	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	445,842,072.68	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>170,003,160.00</u>	<u>1,026,322,745.00</u>

Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгж
ОНӨТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	170,003,160.00	1,026,322,745.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	170,003,160.00	1,026,322,745.00
2200	Дотоод эх үүсвэрээр	170,003,160.00	1,026,322,745.00
223001	Бусад хөрөнгө	-	970,000,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	170,003,160.00	56,322,745.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(170,003,160.00)	(1,026,322,745.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	-	-	-	-	-
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	-	-	-
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	8,208,938,276.76	-	8,208,938,276.76
C08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	8,208,938,276.76	-	8,208,938,276.76
D01	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	-	-	8,208,938,276.76	-	8,208,938,276.76
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	8,208,938,276.76	-	8,208,938,276.76
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	952,198,191.10	-	952,198,191.10
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	9,161,136,467.86	-	9,161,136,467.86

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,641,193,400.00	1,507,744,133.90	133,449,266.10	91.9
УРСГАЛ ЗАРДАЛ	1,641,193,400.00	1,507,744,133.90	133,449,266.10	91.9
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,641,193,400.00	1,507,744,133.90	133,449,266.10	91.9
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,031,245,900.00	957,587,094.83	73,658,805.17	92.9
Үндсэн цалин	929,081,300.00	903,728,064.83	25,353,235.17	97.3
Нэмэгдэл	2,724,600.00	2,310,000.00	414,600.00	84.8
Унаа хоолны хөнгөлөлт	53,240,000.00	41,552,120.00	11,687,880.00	78.0
Урамшуулал	46,200,000.00	9,996,910.00	36,203,090.00	21.6
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	124,595,500.00	121,460,297.55	3,135,202.45	97.5
Тэтгэврийн даатгал	84,725,000.00	82,652,405.77	2,072,594.23	97.6
Тэтгэмжийн даатгал	9,967,600.00	9,723,812.44	243,787.56	97.6
ҮОМШӨ-ний даатгал	7,974,100.00	7,779,049.96	195,050.04	97.6
Ажилгүйдлийн даатгал	1,993,500.00	1,857,404.49	136,095.51	93.2
Эрүүл мэндийн даатгал	19,935,300.00	19,447,624.89	487,675.11	97.6
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	53,000,000.00	31,057,681.00	21,942,319.00	58.6
Байрны түрээс	53,000,000.00	31,057,681.00	21,942,319.00	58.60
Хангамж, бараа материалын зардал	95,934,000.00	91,321,086.00	4,612,914.00	95.2
Бичиг хэрэг	7,640,000.00	5,508,920.00	2,131,080.00	72.1
Тээвэр, шатахуун	60,000,000.00	59,122,676.00	877,324.00	98.5
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	13,294,000.00	11,689,490.00	1,604,510.00	87.9
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	15,000,000.00	15,000,000.00	-	100.0
Эд хогшил, урсгал засварын зардал	46,418,000.00	45,396,405.00	1,021,595.00	97.8
Багаж, техник, хэрэгсэл	36,000,000.00	35,039,405.00	960,595.00	97.3
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	6,400,000.00	6,339,000.00	61,000.00	99.05
Урсгал засвар	4,018,000.00	4,018,000.00	-	100.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	270,000,000.00	242,046,588.00	27,953,412.00	89.6
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	240,000,000.00	212,659,948.00	27,340,052.00	88.6
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	10,000,000.00	10,000,000.00	-	100.00
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	20,000,000.00	19,386,640.00	613,360.00	96.9
Бараа үйлчилгээний бусад зардал	20,000,000.00	18,874,981.52	1,125,018.48	94.4
Бараа үйлчилгээний бусад зардал	20,000,000.00	18,874,981.52	1,125,018.48	94.4
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,641,193,400.00	1,507,744,133.90	133,449,266.10	91.9
ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,641,193,400.00	1,507,744,133.90	133,449,266.10	91.87
Орон нутгийн төсвөөс	1,641,193,400.00	1,507,744,133.90	133,449,266.10	91.87
АЖИЛЛАГСДЫН ТОО	27	21	6	77.8
Удирдах ажилтан	2	1	1	50.0
Гүйцэтгэх ажилтан	25	20	5	80.0

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 180 дугаар тогтоолоор Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулахад чиглэсэн Засгийн газрын гадаадын зээлийн хөрөнгө оруулалттай төсөл, хөтөлбөрийн үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангах болон улс, нийслэлийн төсвийн санхүүжилттэй төсөл, арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгж ОНӨТҮГ-ыг байгуулсан.

Байгууллагын дүрэмд тус нэгжийн зорилгыг Нийслэл Улаанбаатар хотын түгжрэлийг бууруулах, төвлөрлийг сааруулах, нийтийн тээврийн чанар, хүртээмжийг сайжруулах чиглэлээр хэрэгжүүлэх улс, орон нутгийн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх болон Засгийн газрын гадаадын зээлийн хөрөнгийн санхүүжилтээр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийг харилцан уялдуулах, нэгдсэн удирдлагаар хангах, тэдгээрийн зааг, дэс дараа, үр дүнг тооцох явдал гэж тодорхойлсон.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгж ОНӨТҮГ-ын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд тайлант онд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн 411 дүгээр тогтоол Нийслэл Улаанбаатар хотод Их багтаамжийн нийтийн тээврийн хэрэгсэл “Метро” байгуулах тухай;
- Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/17 дугаар захирамж “Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгж ОНӨТҮГ-ын бүтэц, орон тоог шинэчлэн батлах тухай”
- Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/1882 дугаар захирамж “Нийслэлийн нийтийн тээвэрт дүүжин замын тээвэр нэвтрүүлэх төслийн хэрэгжилтийг хангуулах талаар авах зарим арга хэмжээний тухай”
- Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/1476 дугаар захирамж “Улаанбаатар хотын төмөр замын доогуур авто замын нүхэн гарц барих төслийн хэрэгжилтийн тухай”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Тус байгууллагын 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллагын нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд мөрдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулж батлаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 “Аж ахуйн нээж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана” заалттай нийцэхгүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгж ОНӨТҮГ нь 2023 оны санхүүгийн тайлангаа Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 951,198.2 мянган төгрөгөөр буюу 11.6 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
А	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага	1,880.3	3,655.6	1,775.3
Урьдчилгаа	15,000.0	-	(15,000.0)
Бараа материал	8,068,891.9	9,050,748.2	981,856.3
Үндсэн хөрөнгө	132,304.8	115,588.9	(16,715.9)
Нийт хөрөнгө	8,218,077.0	9,169,992.7	951,915.7
Өр төлбөр	9,138.7	8,856.2	(282.5)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	8,208,938.3	9,161,136.5	952,198.2
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	8,218,077.0	9,169,992.7	951,915.7

Өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан авлага, урьдчилгаа, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр, эздийн өмчийн данс байна.

Хувь хүний орлогын албан татварын илүү төлөлт 427.1 мянга, нийгмийн даатгалын шимтгэлийн илүү төлөлт 2,728.4 мянга, Монгол Шуудан ХК-д байршуулсан барьцаа 500.0 мянга, нийт 3,655.6 мянган төгрөгийн авлага тайлагнасан.

Тод индэр ХХК 4,230.0 мянга, Мэдээллийн индэр ТББ 4,860.0 мянга, Ган үзэг үндэсний хэвлэл мэдээллийн холбоо ТББ 5,910.0 мянга, нийт 15,000.0 мянган төгрөгийн хэвлэл, мэдээллийн байгууллагуудад төлсөн гэрээт ажлын урьдчилгааг тайлант онд барагдуулсан.

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 37,337.0 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 27,480.7 мянган төгрөгийн бараа материал зарцуулсан. Нөөцийн бараа материал дансанд 970,000.0 мянган төгрөгийн нийслэлийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн Замын хөдөлгөөний хураамж, зорчилтын хянах системийг цахимжуулах, техник туслалцааны зөвлөх үйлчилгээг бүртгэсэн байна.

Тайланд онд 56,322.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авч, 73,038.7 мянган төгрөгийн элэгдэл байгуулсан байна.

Тээвэр шатахууны төлбөрийг төлөөгүйгээс Нийслэлийн Төр захиргааны авто бааз УТҮГ-т төлөх 3,856.2 мянга, гэрээт ажлын төлөөгүй үлдэгдэл 5,000.0 мянга, нийт 8,856.2 мянган төгрөгийн өр тайлагнасан.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 9,161,136.5 мянган төгрөг болж 952,198.2 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант оны үр дүнгээс шалтгаалжээ.

3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгж ОНӨТҮГ-ын дарга үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгж нь ОНӨТҮГ боловч орлого төвлөрүүлдэггүй, 100 хувь орон нутгийн төсвөөс санхүүждэг тул Нийслэлийн Засаг даргатай контрактын гэрээ байгуулаагүй, зорилтот түвшний төлөвлөгөө батлуулаагүй байна.

Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгж ОНӨТҮГ-т нийслэлийн төсвөөс 1 хөтөлбөрийн 1 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,641,193.4 мянган төгрөг олгохоор батлагдсанаас гүйцэтгэлээр 1,507,744.1 мянган төгрөгийн санхүүжилт авч зарцуулсан.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	71108- Зам тээврийн судалгаа шинжилгээний зардал	1,641,193.4	1,507,744.1	133,449.3	91.9
1.1	80101-Үндсэн үйл ажиллагааны зардал	1,641,193.4	1,507,744.1	133,449.3	91.9
НИЙТ ДҮН		1,641,193.4	1,507,744.1	133,449.3	91.9

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 6.3.1-т тусгагдсан “Нийслэл хотын замын хөдөлгөөн, тээврийн ухаалаг систем төслийг бүрэн хэрэгжүүлнэ” зорилтын хүрээнд Улаанбаатар хотын зам тээврийн нэгдсэн мэдээллийн системийн тогтолцоог бий болгох зорилгоор Замын хөдөлгөөний хураамж, зорчилтыг хянах системийг цахимжуулах, техник туслалцааны зөвлөх үйлчилгээний сонгон шалгаруулалт зарласан.

Энэхүү хөрөнгө оруулалтын ажилд нийслэлийн төсвөөс 970,000.0 мянган төгрөг зарцуулж, биет бус хөрөнгийг захиалагч байгууллага болох нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгж ОНӨТҮГ-т бүртгэсэн.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгж ОНӨТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг сайжруулах, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулж батлах, анхан шатны баримтын бүрдлийг хангаж ажиллах, батлагдсан төсвийг зориулалтын дагуу, үр ашигтай, хэмнэлттэй зарцуулах, авлага, өр төлбөр үүсгэхгүй байх зэрэг зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг НТАГ-ын Санхүү-нийцлийн аудитын хэлтсийн ахлах аудитор Г.Долгорсүрэн гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Отгонбаяр, хэлтсийн дарга Х.Түвшинбаяр, газрын дарга, тэргүүлэх аудитор М.Эрдэнэжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгж ОНӨТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг НТАГ-т 2024 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 1/34 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлыг тооцох эх сурвалжийг санхүүгийн үр дүнгийн тайлан, суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,635,866.3 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 24,538.0 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн. Тус байгууллагын 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүн өмнөх оноос 110,320.4 мянган төгрөгөөр буурсан тул материаллаг байдлын түвшин 1,654.8 мянган төгрөгөөр буурсан.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор дэд захирлыг 2022 оны 4 дүгээр сарын 1-ны өдрөөс чөлөөлсөн, түрээсийн тээврийн хэрэгслийн гэрээг цуцалсан зэрэг арга хэмжээ авч ажилласан байна. Мөн төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, 6 гишүүн, нарийн бичгийн дарга нарт сар бүр нийт 5,350.0 мянган төгрөгийн урамшуулал олгож байсныг 2023 оны 4 дүгээр сараас зогсоосон байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг

тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 4 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгахад байршуулбал зохих мэдээллийг мэдээлээгүй зөрчил илрээгүй. Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль, тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийслэлийн хөрөнгө оруулалтаар хийсэн ажлыг ашиглагч байгууллага хүлээж аваагүй байхад эцсийн санхүүжилт 194,000.0 мянган төгрөгийн олгосон нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.24."төсвийн хөрөнгө оруулалт" гэж улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлж, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгийн зарлагыг", 5 дугаар зүйлийн 5.1.3."санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 6 дугаар зүйлийн 6.3.2."санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв, үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлэн бүртгэж, тайлагнах", Сангийн сайдын 2019 оны 282 тоот тушаал "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах" журмын 9.26 "Эцсийн санхүүжилтийг авахад тухайн барилга байгууламж, тоног төхөөрөмжийг ашиглагч байгууллага нь бүртгэлд тусгасныг нотлох баримт үйлдэж баримт бичгийн иж бүрдэлд хавсаргана.", 7.3.3 "холбогдох материал, нотлох баримтаар баталгаажсан, төлөвлөлт, зорилтод нийцсэн, хэрэгцээ шаардлагад тулгуурласан байх" заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага өгсөн.

Нийслэлийн иргэдийн эрх ашиг хөндсөн шийдвэр гаргахдаа олон нийтийн оролцоог хангаагүй, хэлэлцүүлэг явуулах, санал авах ажил зохион байгуулалгүй нийслэлийн хөрөнгө оруулалтаас 970,000.0 мянган төгрөг зарцуулсан нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.4 "Олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагаанд тухайн орон нутгийн иргэдийн төлөөллийг оролцуулан сонгон шалгаруулалт явуулах бөгөөд тухайн төсөл, арга хэмжээний хэрэгжилт, гүйцэтгэлд орон нутгийн иргэдийг өргөнөөр оролцуулах зарчмыг баримтална." заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөвлөмж өгсөн.

Хөрөнгө оруулалтын ажлаас гэрээний үүргийн биелэлтийг баталгаажуулах барьцаа суутгалгүй санхүүжилт бүрэн олгосон нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.6 "Бараа, ажил, үйлчилгээний чанарын баталгаат болон зүгшрүүлэх тохируулах хугацаанд гүйцэтгэгчийн хүлээсэн үүргийн биелэлтийг баталгаажуулах зорилгоор гэрээний үнийн дүнгийн 5-10 хувийг уг хугацаа дуустал барьцаалах нөхцөлийг захиалагч тендерийн баримт бичигт тусгаж болно." заалтыг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөвлөмж өгсөн.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

2023 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 850,253.5 мянган төгрөгийн зөрчил илэрснийг цаашид давтан гаргахгүй байх 12 зөвлөмж өгсөн.

Хүснэгт 3 Зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт					
Албан шаардлага					
Зөвлөмж	12	850,253.5	10	835,253.5	83.3
Нийт дүн	12	850,253.5	10	835,253.5	83.3

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулж батлуулах, төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх гэсэн зөвлөмжүүдийг хэрэгжүүлээгүй байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Сэлбэ голын дагуу баригдах хурдны замын техник эдийн засгийн үзүүлэлт, байгаль орчны нарийвчилсан үнэлгээ, инженерийн нарийвчилсан зураг төсөл, Туул голын дагуу баригдах хурдны замын техник эдийн засгийн үзүүлэлт, байгаль орчны нарийвчилсан үнэлгээ, инженерийн нарийвчилсан зураг төслийг 8,044,442.2 мянган төгрөгөөр бараа материалын дансанд бүртгэсэн. Энэхүү зураг төслөөр ажил гүйцэтгэх, шаардагдах хөрөнгө оруулалтын зардлыг хаана төсөвлөсөн нь тодорхойгүй байна.

Нөөцийн бараа материал дансанд бүртгэсэн 970,000.0 мянган төгрөгийн өртөг бүхий Замын хөдөлгөөний хураамж, зорчилтын хянах системийг цахимжуулах, техник туслалцааны зөвлөх үйлчилгээг ашиглагч байгууллагад шилжүүлсэн эсэхийг дараагийн аудитаар анхаарах нь зүйтэй гэж үзлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой 40,060.1 мянган төгрөгийн 3 алдаа¹ илэрснийг санхүүгийн тайланд залруулга хийлгэж, баталгаажуулав. Үүнд:

- Тайлант оны элэгдлийн зардлыг 8,104.7 мянган төгрөгөөр дутуу тайлагнасныг санхүүгийн үр дүнгийн тайланд залруулсан.
- Санхүүгийн үр дүнгийн тайланд 11,000.0 мянган төгрөгийн зардлын ангилал буруу бүртгэсэн.
- Нийт 20,955.4 мянган төгрөгийн хөрөнгийн ангилал буруу бүртгэснийг санхүүгийн байдлын тайланд залруулсан.

Аудитаар нийт 139,862.3 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс алдаа зөрчлийг арилгах 44,944.0 мянган төгрөгийн 6 албан шаардлагыг хүргүүлж, цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх 94,918.3 мянган төгрөгийн 3 зөвлөмж өгсөн.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл

5.1 Албан шаардлага

1. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулж батлаагүй, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана" заалттай нийцэхгүй байна.

2. Төсвийг зохистой удирдаагүйгээс 3,155.5 мянган төгрөгийн авлага, 3,856.2 мянган төгрөгийн өр төлбөр үүсгэсэн, өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" заалттай нийцэхгүй байна.

3. Бүх ажилтанд ээлжийн амралтын цалин олгоогүй үндсэн цалинг бүтэн олгосон, цагийн бүртгэл анхан шатны баримтад хавсаргаагүй тул биеэр эдэлсэн эсэх нь тодорхойгүй нь Хөдөлмөрийн тухай хуулийн 99 дүгээр зүйлийн 99.1 "Ажилтанд ажлын жил бүр ээлжийн амралт олгож биеэр эдлүүлнэ. Ажлын зайлшгүй шаардлагаар ээлжийн амралтаа биеэр эдэлж чадаагүй ажилтанд олгох мөнгөн урамшууллын хэмжээг энэ хуулийн 110.2-т заасан хэмжээнээс нэмэгдүүлж олгох асуудлыг хамтын гэрээгээр, хамтын гэрээгүй бол ажилтантай тохиролцон олгоно." заалтыг зөрчсөн байна.

4. Нягтлан бодогч няравын ажил давхар гүйцэтгэсэн нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5. "Албан тушаалтан ашиг сонирхлын зөрчилд орж болох нөхцөл байдлыг мэдэгдэх, түүнээс татгалзах замаар урьдчилан сэргийлнэ.", 11 дүгээр зүйлийн 11.1 "Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны акт гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно." заалтуудтай нийцэхгүй байна.

5. Дуудлагын автомашиныг амралтын өдөр, илүү цагаар хэрэглэж 14,692.3 мянган төгрөгийн төсвийг үрэлгэн зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;" заалтыг зөрчсөн байна.

6. Тайлант онд нийт 18,240.0 мянган төгрөгийн бараа материалыг шаардах хуудас бичилгүй, зарцуулсан нь Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын хавсралт Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх зааврын 6. "Материалын үнэ бүхий зүйлсийг байгууллагын үйлдвэрлэл, дотоод хэрэгцээнд зарцуулах шаардлага гарсан үед уг зүйлийг авч зарцуулах хүн "Шаардах хуудас"-ыг 1 хувь үйлдэж зөвшөөрөл авна.", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно." заалтуудыг зөрчсөн байна.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгө, бараа материалын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Санхүүгийн тайланд бүртгэлтэй 27,802.8 мянган төгрөгийн биет бус хөрөнгийг тоолоогүй, 12,240.7 мянган төгрөгийн бараа материалыг бөөн дүнгээр бүртгэсэн, албан хаагчийн эд хөрөнгийн ашиглалтын картад хангамжийн материалыг бүртгээгүй нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2 "Эд хөрөнгийн дотоодын

тооллогыг төрийн өмчит хуулийн этгээдийн захиргаа эрхлэн дор дурдсан хугацаанд явуулж улирал, жилийн тайлан тэнцэлд тусгаж тайлагнана: 1/ үндсэн хөрөнгө, дуусаагүй хөрөнгө оруулалт ба барилга угсралтын ажил, их засварын зардлын тооллогыг жилд нэг удаа /12 дугаар сарын 01-нээс 31-ний дотор/, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална: 5.1.4.үнэн зөв байх" заалтуудыг хэрэгжүүлээгүй.

Өгсөн зөвлөмж: Хөрөнгийн тооллогыг чанартай гүйцэтгэх, хөрөнгөд бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах

Илрүүлэлт: Тайлант онд худалдан авсан 19,774.8 мянган төгрөгийн хөрөнгийг худалдан аваад гэрээ дүгнэж акт үйлдээгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна." заалтыг хэрэгжүүлээгүй.

Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн гүйлгээг данс бүртгэлд тусгахдаа анхан шатны баримтын бүрдлийг хангаж ажиллах

Илрүүлэлт: Тайлант онд 35,100.00 мянган төгрөгийн төсвийн хөрөнгөөр хийгдсэн видео шторк, контентыг шууд зардлаар бүртгэсэн нь Зар сурталчилгааны тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 "Зар сурталчилгаа захиалагч, бүтээгч, түгээгч зар сурталчилгаатай холбоотой баримт болон тэдгээрийн хуулбарыг тухайн зар сурталчилгааг сүүлчийн удаа түгээснээс хойш 6 сараас доошгүй хугацаагаар хадгална." заалтуудыг хэрэгжүүлээгүй.

Өгсөн зөвлөмж: Төсвийн хөрөнгөөр хийгдсэн видео шторк, контентыг Зар сурталчилгааны тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д заасны дагуу бараа материалын дансанд бүртгэж, хугацаа нь дуусмагц байгууллагын даргын шийдвэрийг үндэслэн бүртгэлээс хасаж байх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Санхүүгийн үр дүнгийн тайланд элэгдлийн зардал дутуу тайлагнасан.	1	8,104.7			1	8,104.7	1	8,104.7				
Санхүүгийн үр дүнгийн тайланд зардлын ангилал буруу бүртгэсэн.	1	11,000.0			1	11,000.0	1	11,000.0				
Хөрөнгийн ангилал буруу бүртгэсэн.	1	20,955.4			1	20,955.4	1	20,955.4				
ДҮН	3	40,060.1			3	40,060.1	3	40,060.1				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулж батлаагүй, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй.	1	-			1	-						
Бүх ажилтанд ээлжийн амралтын цалин олгоггүй үндсэн цалинг бүтэн олгосон, цагийн бүртгэл анхан шатны баримтад хавсаргаагүй тул биеэр эдэлсэн эсэх нь тодорхойгүй.	1	-			1	-						
Нягтлан бодогч няравын ажил давхар гүйцэтгэсэн.	1	-			1	-						
Төсвийг зохистой удирдаагүйгээс авлага, өр төлбөр үүсгэсэн.	1	7,011.7			1	7,011.7						
Биет бус хөрөнгө тоолоогүй, бараа материалыг бөөн дүнгээр бүртгэсэн, албан хаагчийн эд хөрөнгийн ашиглалтын картад хангамжийн материалыг бүртгээгүй.	1	40,043.5					1	40,043.5				
Бараа, үйлчилгээ худалдан аваад гэрээ дүгнэж акт үйлдээгүй.	1	19,774.8					1	19,774.8				
Дуудлагын автомашиныг амралтын өдөр, илүү цагаар хэрэглэж төсвийг үрэлгэн зарцуулсан.	1	14,692.3			1	14,692.3						
Тайлант онд төсвийн хөрөнгөөр хийгдсэн видео шторк, контентыг шууд зардлаар бүртгэсэн.	1	35,100.0					1	35,100.0				
Бараа материалыг шаардах хуудасгүйгээр зарцуулсан.	1	18,240.0			1	18,240.0						
ДҮН	9	134,862.3			6	39,944.0	3	94,918.3				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Ашиглагч байгууллага хүлээж аваагүй байхад эцсийн санхүүжилт олгосон.	1	194,000.0			1	194,000.0		
Нийслэлийн иргэдийн эрх ашиг хөндсөн шийдвэр гаргахдаа олон нийтийн оролцоог хангаагүй, хэлэлцүүлэг явуулах, санал авах ажил зохион байгуулаагүй.	1	970,000.0					1	970,000.0
Хөрөнгө оруулалтын ажлаас гэрээний үүргийн биелэлтийг баталгаажуулах барьцаа суутгалгүй санхүүжилт бүрэн олгосон.	1						1	
ДҮН	3	1,164,000.0			1	194,000.0	2	970,000.0